



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/53

Булган сум

Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг,
байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,
үнэлгээ хийсэн дүнгийн тухай


Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2021 оны А/207 дугаар захирамжаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 11.1, 11.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагуудын 2023 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр шилдэг байгууллагаар шалгарсан Соёл, урлагийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газрыг тус бүр хоёр сая төгрөгөөр шагнаж урамшуулсугай.

2.Шагнал урамшуулалд шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

3.Өргөмжлөлд шаардагдах хөрөнгийг шагналын мөнгөнөөс суутгаж олгосугай.

ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ